

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ

ТОГТООЛ

20.. оны .. сарын... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тогтоол, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.1, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 179 дүгээр тогтоолоор баталсан “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д доор дурдсан агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй:

1/ Журмын 1.2.4 дэх заалт:

“1.2.4. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 4.1.4, 7.2-т тус тус заасан холбогдох этгээд, эрх бүхий албан тушаалтан, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбооны удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал.”

2/ Журмын 2.5 дахь хэсэг:

“2.5.Энэ журмын 1.2, 1.3-т заасан хувь хүн, хуулийн этгээдийг тохиромжтой этгээд эсэхийг тодорхойлох асуулгыг Хороо батална.”

3/ Журмын 3.2.1.4, 3.2.1.5, 3.2.1.6 дахь дэд заалт:

“3.2.1.4.үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, брокер, комплаенсын ажилтан нь дээд болон түүнээс дээш боловсролтой байх.

3.2.1.5.үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, комплаенсын ажилтан нь бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой байх.

3.2.1.6.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн гүйцэтгэх удирдлага болон Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан нь санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, мэдээллийн технологи, компанийн засаглалын нэг, эсхүл хэд хэдэн чиглэлээр мэргэшсэн байх.”

2.Энэ тогтоолын 1-д заасан журмын 1.1 дэх хэсгийн “мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч” гэсний дараа “, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” гэж, 1.2.1 дэх заалтын “тусгай зөвшөөрөл хүсэгч” гэсний дараа “, бүртгүүлэхээр хүсэлт гаргагч” гэж, “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэсний дараа “, бүртгэлтэй” гэж, “мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч” гэснийг “, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” гэж, “албан тушаалтан” гэсний дараа “, комплаенсын ажилтан” гэж, 3.1.3.1 дэх дэд заалтын “хүчингүй болгох” гэсний дараа “, хязгаарлах, түр зогсоох, бүртгэлээс хасах” гэж, 3.2.1.1 дэх дэд заалтын “зэрэг эрх бүхий албан тушаалд” гэсний дараа “, эрх бүхий албан тушаалтан, комплаенсын ажилтанд” гэж тус тус нэмсүгэй.

3.Тогтоолын 1-д заасан журмын 1.1 дэх хэсгийн “тусгай зөвшөөрөлтэйгөөр” гэснийг “тусгай зөвшөөрөл, бүртгэлтэйгээр” гэж, 1.3 дахь хэсгийн “энэхүү журмын Хавсралт 1” гэснийг “энэ журмаар” гэж, 3.1.5.2, 3.2.4.2 дахь дэд заалтуудад тус тус “хуульд” гэснийг “хууль, журамд” гэж, 3.1.2.1 дэх дэд заалтын “журамтай” гэснийг “журам, хөтөлбөртэй” гэж, 4.8.1 дэх заалтын “авахаар” гэснийг “авах, бүртгүүлэхээр” гэж, 4.8.3 дахь заалтын “тушаалтан өөрчлөгдөх” гэснийг “тушаалтны өөрчлөлтийг бүртгүүлэх” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 179 дүгээр тогтоолын тэргүү болон 1 дэх заалтын “банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх” гэснийг, мөн тогтоолоор баталсан журмын нэрийн “банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх” гэснийг, 3.2.1.4 дэх дэд заалт, 1, 2 дугаар хавсралтыг бүхэлд нь тус тус хассугай.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН